

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

"Сэлэнгэ цэнгэг ус" ААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2026/004/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 70363040 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 70363036 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn Аудитын гүйцэтгэсэн: Бэйкер Тилли Далайван аудит ХХК-н Дархан салбар Утас: 99396969 Цахим хаяг: urtaa6969@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



“СЭЛЭНГЭ ЦЭНГЭГ УС” ААТҮГ-ЫН
ДАРГА Э.ЭРДЭНЭСАЙХАН ТАНАА

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2020.02.15 № СЭА-2026/004/НА-СТА-ОНӨҮГ
танай _____ -ны № _____ -т

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Сэлэнгэ цэнгэг ус” ААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Сөрөг дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн мэдэгдэхүйц нөлөөллийн улмаас 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулаагүй, байгууллагын үйл ажиллагаа, хөрөнгийн худалдан авалт, санхүү, бүртгэл, тайлагналтад оршиж буй зөрчил материаллаг буюу өргөн хүрээгээр тархсан байна.

Сөрөг санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан аудитын сөрөг дүгнэлтийн суурь болоход хангалттай бөгөөд зохистой гэдэгт итгэж байна.

Аудитаар дараах зөрчлүүд илэрсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.7, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоол, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь заалтууд болон санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:

СЭА-2026/004/НА-СТА-ОНӨҮГ

4326050331³

- Өмнөх албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс боловсруулж, батлуулсан 2025 оны санхүүгийн төлөвлөгөөнд орлогыг 4,405,970.1 мянган төгрөг байхаар төлөвлөсөн боловч 2,854,105.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, төлөвлөгөөг 1,551,864.5 мянган төгрөгөөр тасалсан,
- Сургалтын гэрээ, анхан шатны баримтгүйгээр байгууллагын даргаар ажиллаж байсан А.Алтансүхийн сургалтын төлбөрт 3,500.0 мянган төгрөгийг төлж зардлаар тайлагнасан,
- Тайлант хугацааны эцэст татвар болон нийгмийн даатгалын байгууллагатай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүйгээс санхүүгийн тайланд татварын өр төлбөр 27,994.6 мянган төгрөгөөр илүү, нийгмийн даатгалын өр төлбөр 9,747.3 мянган төгрөгөөр дутуу тайлагнагдсан,
- Тайлант онд 92,659.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, сэлбэг, бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй,
- Албан томилолтын хуудасгүй, гүйцэтгэсэн ажлын тайлангүй, анхан шатны баримтгүй 18,568.4 мянган төгрөгийн албан томилолтын зардал олгож, бүртгэл тайланд тусгасан,
- Шууд худалдан авах босго үнээс давсан 266,494.6 мянган төгрөгийн шатахууны зардал, 77,230.0 мянган төгрөгийн нормын хувцас, 122,250.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг шууд худалдан авсан,

Асуудлыг онцолсон хэсэг

“Сэлэнгэ цэнгэг ус” ААТҮГ нь тайлант онд аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдсэн 147,400.0 мянган төгрөгийн “Бохир сордог машин” үнэ төлбөргүйгээр хүлээн авсан бөгөөд 66,014.4 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч бүртгэл тайланд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Тайлант оны орлогыг 4,405,471.0 мянган төгрөгөөр, нийт зардлыг 4,963,839.9 мянган төгрөгөөр, алдагдлыг 558,368.9 мянган төгрөгөөр төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 2,856,832.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 3,592,372.2 мянган төгрөгийн зардал гарган, 735,539.4 мянган төгрөгийн алдагдал хүлээж өөрийгөө санхүүжүүлэн ажиллаж чадахгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

“Сэлэнгэ цэнгэг ус” ААТҮГ-ын 2025 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 45 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 80 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12 сарын 31-ний өдөр
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	7,477,145.96	35,373,463.19
1.1.2	Дансны авлага	2,210,149,866.01	2,497,496,601.66
1.1.4	Бусад авлага	2,243,198.54	
1.1.6	Бараа материал	246,595,708.68	222,786,762.85
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		2,243,198.54
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,466,465,919.19	2,757,900,026.24
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	5,229,229,616.50	4,771,372,432.25
1.2.2	Биет бус хөрөнгө	676,631,424.30	673,725,100.85
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,905,861,040.80	5,445,097,533.10
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	8,372,326,959.99	8,202,997,559.34
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	10,493,616.38	110,101,179.48
2.1.1.3	Татварын өглөг	1,458,794,773.71	1,595,224,546.15
2.1.1.4	НДШ-ийн өглөг	1,221,070,046.03	1,427,267,331.20
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	13,323,584.94	
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,703,682,021.06	3,132,593,056.83
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	6,698,800.00	6,698,800.00
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	2,710,380,821.06	6,698,800.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	-	3,139,291,856.83
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч : а) төрийн	1,574,064,600.00	1,574,064,600.00
2.3.2	б) хувийн		
2.3.3	б) хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	5,418,270,111.89	5,418,270,111.89
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	2,148,734,932.11	2,296,134,932.11
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(3,479,123,505.07)	(4,224,763,941.49)
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	5,661,946,138.93	5,063,705,702.51
2.4	ӨР ТӨЛБӨР ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН	8,372,326,959.99	8,202,997,559.34

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого /цэвэр/	2,845,623,558.00	2,854,105,600.12
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	3,510,208,873.10	3,510,512,043.23
3	Нийт ашиг (алдагдал)	(664,585,315.10)	(656,406,443.11)
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого		
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		
9	Борлуулалт маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	50,598,867.00	45,745,111.45
11	Санхүүгийн зардал	30,432,962.24	43,488,881.86
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз /гарз/		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз /гарз/		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз /гарз/		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз /гарз/		
17	Бусад ашиг /алдагдал/		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(745,617,144.34)	(745,640,436.42)
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(745,617,144.34)	(745,640,436.42)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг /алдагдал/		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(745,617,144.34)	(745,640,436.42)
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз /гарз/		
24	Орлогын нийт дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,574,064,600.0	5,161,385,136.3	1,364,716,091.5	(2,743,584,145.3)	5,356,581,682.6
3	Залруулсан үлдэгдэл	1,574,064,600.0	5,161,385,136.3	1,364,716,091.5	(2,743,584,145.3)	5,356,581,682.6
4	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
5	Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	784,018,840.6	-	784,018,840.6
6	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(735,539,359.7)	(735,539,359.7)
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	256,884,975.6	-	-	256,884,975.6
8	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,574,064,600.0	5,418,270,111.9	2,148,734,932.1	(3,479,123,505.1)	5,661,946,138.9
9	Залруулсан үлдэгдэл	1,574,064,600.0	5,418,270,111.9	2,148,734,932.1	(3,479,123,505.1)	5,661,946,138.9
10	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
11	Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	147,400,000.0	-	147,400,000.0
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(745,640,436.4)	(745,640,436.4)
13	2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,574,064,600.0	5,418,270,111.9	2,296,134,932.1	(4,224,763,941.5)	5,063,705,702.5

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,547,185,610.09	2,487,222,115.07
	Бараа борлуулсан үйлчилгээний орлого	2,526,034,710.09	2,457,222,115.07
	Татаас санхүүжилтийн орлого	21,150,900.00	30,000,000.00
	Бусад мөнгөн орлого		
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,374,669,210.66	2,392,703,170.56
	Ажиллагчдад төлсөн	1,172,760,299.30	1,217,471,058.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	122,227,155.94	202,099,512.00
	Бараа материал худалдан авахад төлсөн	344,799,569.82	296,034,460.57
	Ашиглалтын зардалд төлсөн	442,790,573.92	486,827,238.99
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	133,473,019.00	105,222,618.57
	Хүүний төлбөрт төлсөн	6,161,129.90	7,884,851.86
	Татварын байгууллагад төлсөн	99,545,871.67	-
	Бусад мөнгөн зарлага	52,911,591.11	77,163,430.57
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	172,516,399.43	94,518,944.51
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	166,719,000.00	66,622,627.28
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	166,719,000.00	66,622,627.28
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(166,719,000.00)	(66,622,627.28)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	5,797,399.43	27,896,317.23
5.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,679,746.53	7,477,145.96
5.2	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,477,145.96	35,373,463.19

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмж их нэгж	2025 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөг өө	Гүйцэтгэл		
1	ОРЛОГЫН ДҮН	м/төг	4,405,970.1	2,854,105.6	(1,551,864.5)	64.8
	Үйл ажиллагааны орлого	м/төг	4,384,320.1	2,824,105.6	(1,560,214.5)	64.4
	Татаас санхүүжилт	м/төг	21,650.0	30,000.0	8,350.0	138.6
2	ЗАРЛАГА ДҮН	м/төг	4,963,840.0	3,599,746.0	(1,364,093.9)	72.5
	ЦАЛИН	м/төг	1,920,416.0	1,646,084.1	(274,331.9)	85.7
	НД-ийн шимтгэл	м/төг	278,460.3	202,099.5	(76,360.8)	72.6
	ҮХ элэгдэл	м/төг	778,068.1	674,786.1	(103,282.0)	86.7
	Цахилгаан	м/төг	288,970.7	275,847.1	(13,123.6)	95.5
	Шатахуун, тээврийн зардал	м/төг	266,494.6	67,403.0	(199,091.6)	25.3
	Дулаан	м/төг	307,583.6	202,755.9	(104,827.7)	65.9
	Буцалтгүй тусламж	м/төг	19,640.0	6,215.0	(13,425.0)	31.6
	Материал	м/төг	198,760.0	10,256.8	(188,503.2)	5.2
	Үндсэн хөрөнгө худалдан авалт	м/төг	122,250.0	66,014.4	(56,235.6)	54.0
	Хөдөлмөр хамгаалал, ариутгал халдваргүйжүүлэлтийн зардал	м/төг	77,230.0	58,071.1	(19,158.9)	75.2
	Холбоо	м/төг	25,640.0	15,372.3	(10,267.7)	60.0
	Сургалт	м/төг	21,845.0	9,463.6	(12,381.4)	43.3
	Томилот	м/төг	43,520.0	27,631.5	(15,888.6)	63.5
	Тээврийн хэрэгслийн татвар	м/төг	1,250.0	1,028.4	(221.6)	82.3
	НӨАТ, ХАОАТ, суутган	м/төг	384,331.8	274,818.1	(109,513.7)	71.5
	Ус ашигласны татвар	м/төг	20,989.4	35.0	(20,954.4)	0.2
	Урсгал засвар	м/төг	65,241.0	5,093.9	(60,147.1)	7.8
	Программ хангамжийн зардал	м/төг	11,588.4	2,906.3	(8,682.1)	25.1
	Аудитын зардал	м/төг	3,500.0	3,500.0	0.0	100.0
	Даатгал	м/төг	5,208.0	3,889.5	(1,318.5)	74.7
	Хүү торгуулийн зардал	м/төг	10,944.0	500.0	(10,444.0)	4.6
	Зохицуулах үйлчилгээний хөлс	м/төг	19,964.0	8,000.0	(11,964.0)	40.1
	Харуул хамгаалалтын зардал	м/төг	54,000.0	5,000.0	(49,000.0)	9.3
	Бусад зардал	м/төг	37,945.0	32,974.4	(4,970.7)	86.9
3	Үйл ажиллагааны ашиг алдагдал (1-2)	м/төг	(557,870.0)	(745,640.4)	(187,770.5)	133.7
4	Орлогын татвар (3*10%)	м/төг				
5	ЦЭВЭР АШИГ, АЛДАГДАЛ (3-4)	м/төг	(557,869.9)	(745,640.4)	(175,294.2)	133.7

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой **636,795.7** мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

- Тайлант онд худалдаж авсан 13,226.2 мянган төгрөгийн бараа материалыг санхүүгийн тайланд тусгаагүй,
- Санхүүгийн тайланд дансны авлагыг 15,823.1 мянган төгрөгөөр илүү тайлагнасан,
- Санхүүгийн тайланд дансны өглөгийг 53,723.7 мянган төгрөгөөр илүү тайлагнасан,
- Санхүүгийн тайланд тусгасан бараа материалын нийт орлого 70,846.8 мянган төгрөгөөр, нийт зарлага 35,911.7 мянган төгрөгөөр нярвын тайлангаас зөрүүтэй тусгасан,
- Борлуулалтын орлого 14,782.6 мянган төгрөгийг бүртгэхдээ хувь хүнд өгөх, байгууллагад өгөх өглөг дансыг бууруулж бүртгэсэн,
- Орлогын дэлгэрэнгүй тайланд борлуулалтын орлогыг 1,597.7 мянган төгрөгөөр илүү тайлагнасан,
- Мөнгөн гүйлгээний тайланд 4,499.8 мянган төгрөгийн орлогыг илүү тайлагнасан,
- Өмнөх үеийн хуримтлагдсан ашиг, алдагдал дансыг 59,040.6 мянган төгрөгөөр бууруулж тайлагнасан,
- Шатахууны зардал 14,218.0 мянган төгрөгийг шууд зардлаар бүртгэсэн,
- Татварын цахим системд 263,596.3 мянган төгрөгөөр борлуулалтын орлого илүү шивсэн,
- Санхүүгийн тайланд тайлант хугацаанд төлсөн татварыг 32,297.6 мянган төгрөгөөр илүү тайлагнасан,
- Нийгмийн даатгалын тайланд тооцсон цалинг 11,391.1 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан,
- ХХОАТ-ын тайланд тооцсон цалинг 45,840.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан,

Дээрх алдаанууд нь нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, Нийгмийн даатгалын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх “*Ажил олгогч тухайн сарын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг дараа сарын 05-ны дотор цахим, эсхүл тоон гарын үсгээр баталгаажуулж, харьяалагдах нийгмийн даатгалын байгууллагад ирүүлэх бөгөөд энэ хугацаанд долоо хоног бүрийн амралт, эсхүл нийтээр амрах баярын өдөртэй давхацвал дараагийн ажлын өдөр тайлагнана*” гэсэн заалтууд болон НББОУС-1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, НББОУС-2 “Бараа материал”, “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг тус тус хангаагүй байна.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс **1,721,499.5** мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг

байдлын түвшнээс 1,692,922.5 мянган төгрөгөөр давсан тул **Сөрөг дүгнэлт өглөө.**

Аудитаар нийт **1,721,499.5** мянган төгрөгийн 7 зөрчил¹ илрүүлснээс 3,500.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,700,834.4 мянган төгрөгийн зөрчилд 4, хариуцлага тооцуулах 1 албан шаардлага, 17,165.1 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй ажиллах 2 зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Сургалтын гэрээ, анхан шатны баримтгүйгээр байгууллагын даргаар ажиллаж байсан А.Алтансүхийн сургалтын төлбөрт 3,500.0 мянган төгрөгийг төлж зардлаар тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Сургалтын төлбөрийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.2 Албан шаардлага

1.Өмнөх албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс боловсруулж, батлуулсан 2025 оны санхүүгийн төлөвлөгөөнд орлогыг 4,405,970.1 мянган төгрөг байхаар төлөвлөсөн боловч 2,854,105.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, төлөвлөгөөг **1,551,864.5** мянган төгрөгөөр тасалсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь “*Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах*” гэсэн заалт болон аймгийн Засаг даргын баталсан “Сэлэнгэ цэнгэг ус” ААТҮГ-ын “*2025 оны санхүүгийн орлого, зарлагын нэгдсэн төлөвлөгөө*” заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Орлогыг тооцоо судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөж, төлөвлөгөөг биелүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэх.

2.Тайлант хугацааны эцэст татвар болон нийгмийн даатгалын байгууллагатай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүйгээс санхүүгийн тайланд татварын өр төлбөр 27,994.6 мянган төгрөгөөр илүү, нийгмийн даатгалын өр төлбөр 9,747.3 мянган төгрөгөөр дутуу тайлагнагдсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ...*”, “20.2.7: “*Аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, ...*” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох байгууллагуудтай тооцоо нийлж, төлбөрийн үлдэгдлийг тулган баталгаажуулсны үндсэн дээр авлага, өр төлбөрийг үнэн зөв тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэх.

3. Тайлант онд 92,659.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, сэлбэг, бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна. Энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*”, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь “*Зардал бодитой гарсан бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан баримт болон холбогдох бүртгэлээр баталгаажсан байх*”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “*Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм...*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж байх албан шаардлага хүргүүлэх.

4. Албан томилолтын хуудасгүй, гүйцэтгэсэн ажлын тайлангүй, анхан шатны баримтгүй 18,568.4 мянган төгрөгийн албан томилолтын зардал олгож, бүртгэл тайланд тусгасан байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан томилолтоор ажиллах удирдамж, томилолтын хуудас, гүйцэтгэсэн ажлын тайлан, анхан шатны баримтыг бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх албан шаардлага хүргүүлэх.

5. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс алдаа, зөрчлийг давтан гаргасан, холбогдох албан тушаалтнууд албан үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн, албан тушаалын эрх мэдлээ хэтрүүлэн ажилласан байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйл 42.1 дэх “*...хүчин төгөлдөр болсон албан шаардлага, ...ыг хугацаанд нь биелүүлээгүй ..., санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно*” гэсэн заалтын дагуу дарга Э.Эрдэнэсайхан, ерөнхий нягтлан бодогч А.Цээсүрэн нарт **сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага** хүргүүлэх.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дансны өглөгтэй холбоотой

1.1 Илрүүлэлт: Айл өрх, аж ахуй нэгжид өгөх өглөг дансанд 17,165.1 мянган төгрөгийн урьдчилж орсон орлого буюу өмнөх онуудын илүү төлөлтийг тусгасан ба тайлант онуудад тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Энэ нь НББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах”, гэсэн заалттай нийцээгүй бөгөөд “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Айл өрх, аж ахуй нэгжийн илүү төлсөн төлбөрийг дараа оны усны төлбөрт суутган тооцоо нийлж баталгаажуулж байх.

2.1 Илрүүлэлт: Байгууллагын дотоод журамд эмчилгээний зардалд олгох мөнгөн дүнг тодорхой тусгаагүй, тусламжийн мөнгөн хэмжээг байгууллагын дарга тогтоон гэж заасан нь албан хаагчдад харилцан адилгүй олгох эрсдэл үүсгэж байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.6 “хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцсэн хөдөлмөрийн дотоод журам баталж мөрдүүлэх”, гэсэн заалттай нийцээгүй бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Байгууллагын дотоод журамд эмчилгээний зардалд олгох мөнгөн дүнг тодорхой тусгаж өгөх

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Запруулсан		Запруулаагүй		Тоо	Дүн
Тайлант онд худалдаж авсан бараа материалыг орлогод аваагүй	1	13,226.2	1	13,226.2			1	13,226.2				
Санхүүгийн тайланд авлага илүү тайлагнасан	1	15,823.1			1	15,823.1	1	15,823.1				
Санхүүгийн тайланд өглөг илүү тайлагнасан	1	53,723.7			1	53,723.7	1	53,723.7				
Санхүүгийн тайланд тусгасан орлого, зарлагын нийт дүн нярвын	1	106,758.5			1	106,758.5	1	106,758.5				

Албан томилолтын хуудасгүй, гүйцэтгэсэн ажлын тайлангүй, анхан шатны баримтгүй албан томилолтын зардал олгосон	1	18,568.4			1	18,568.4						
Татвар болон нийгмийн даатгалтай тооцоо нийлц баталгаажуулаагүй санхүүгийн тайланд нийгмийн даатгал, татварын өр төлбөрийг илүү, дугуу тайлагнасан	1	37,741.9			2	37,741.9						
Төлбөрийн цахим баримтаар баталгаажуулаагүй худалдан авалт хийсэн	1	92,659.6			1	92,659.6						
Өмнөх онуудын айл өрх, аж ахуй нэгжийн илүү төлөлтийг тооцоо нийлж баталгаажуулаагүй	1	17,165.1					1	17,165.1				
Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс алдаа, зөрчлийг давтан гаргасан	1								1			
Дүн	8	1,721,499.5	1	3,500.0	5	1,700,834.4	1	17,165.1	1			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Шилэн дансны мэдээллийг 3 удаа хоцроосон	1							1	
Дүн	1							1	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Худалдан авалтыг хуулийн дагуу зохион байгуулаагүй	3	465,974.6			3	465,974.6			
Дүн	3	465,974.6			3	465,974.6			
Нийт дүн	4	465,974.6			3	465,974.6		1	

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ	1						1	
	НИЙТ	1						1	